



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

**Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч
бүртгэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс шилжүүлсэн нийт 76,739,500.00 (далан зургаан сая долоон зуун гучин есөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 33,671,600.00 (гучин гурван сая зургаан зуун далан нэгэн мянга зургаан зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Онцгой байдлын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2023 оны 05 дугаар сарын 05 өдрийн
 0839 дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын ерөнхий газрын харьяа газарт
 газарт эзэмшүүлж, бүртгэх хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Тоо хэмжээ | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элдэгдэл /төгрөг/ | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Шилжүүлэн авах байгууллага |
|-----|---|-------------------------|---------------|--|---|---|--|
| 1 | Тусгай зориулалтын автомашин, Дун фэн маркийн улсын дугаар 66-31 УБП | 2009 | 1 | 8,400,000.00 | | | Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар |
| 2 | Суудлын автомашин, Старекс улсын дугаар 25-41 УНК | 2016 | 1 | 11,089,500.00 | 8,871,600.00 | 2,217,900.00 | Дундговь аймгийн Онцгой байдлын газар |
| 3 | Суудлын автомашин, Хьюндай каунти улсын дугаар 87-42 УНЧ | 2018 | 1 | 12,250,000.00 | 9,800,000.00 | 2,450,000.00 | Онцгой байдлын газар |
| 4 | Суудлын автомашин, Инфинити, улсын дугаар 00-47УБН | 2020 | 1 | 45,000,000.00 | 15,000,000.00 | 30,000,000.00 | Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Ар тал 115 дугаар анги |
| | Нийт дүн | | | 76,739,500.00 (далан зургаан сая долоон зуун есөн гүйеин есөн мянга таван зуу) | 33,671,600.00 (гучин гурван сая зургаан зуун далан нэгэн мянга зургаан зуу) | 34,667,900.00 (гучин дөрвөн сая зургаан зуун жаран долоон мянга есөн зуу) | |